

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛ, ҮР ДҮН СУУРИЛСАН
САНХҮҮЖИЛТИЙН ТОГТОЛЦОО, ҮР НӨЛӨӨ

АУДИТЫН КОД: ӨМА-2023/19-15-ШТА-ГА

ГҮЙЦЭТГЭЛД СУУРИЛСАН САНХҮҮЖИЛТИЙН
ТОГТОЛЦООГ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

Даланзадгад хот 2023 он



Дарга, Тэргүүлэх аудитор Ц.Өсөхбаяр

Утас: 70533539 Цахим хаяг: Usukhbayarts@audit.gov.mn

Аудитын менежер Т.Хонгорзул

Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn

Ахлах аудитор Г.Шижирболд

Утас: 70533552 Цахим хаяг: Shijirboldg@audit.gov.mn

Аудитор Т.Хишигбат

Утас: 70533552 Цахим хаяг: Khishigbatt@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу: Цахим хаяг: www.audit.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлал	2
Хүснэгтийн жагсаалт	2
Графикийн жагсаалт	2
Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх	3-4
ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	4

БҮЛЭГ 1. Эрүүл мэндийн даатгалын тогтолцоо, үйл ажиллагаа бүрэн хэвшээгүй, тогтолцооны үр дүнг тооцох хугацаа богино байна 5-6

A.1.1 Аймгийн хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд тусгасан зорилт, арга хэмжээний хэрэгжилт хангагдсан байна	5
A.1.2 Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөл хууль тогтоомж, дүрэмд заасан чиг үүргээ хэрэгжүүлсэн байна	5
A.1.3 Эрүүл мэндийн даатгалын үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог сайжруулах шаардлагатай байна.....	6

БҮЛЭГ 2. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогыг төлөвлөгөөг тооцоо судалгаанд үндэслээгүй 7-10

B.1.1 Эрүүл мэндийн даатгалын сангийн 2022 оны орлогын төлөвлөгөө 13.1%-аар тасарсан байна	7
B.1.2 Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтийг зохих журмын дагуу хянаж, гүйцэтгэлийг бодитой тайлагнасан байна	8
B.1.3 Хүний нөөцөө оновчтой удирдах шаардлагатай байна	9
B.1.4 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагын сонгон шалгаруулалт ил тод байдлыг хангасан байна	10
B.1.5 Эрүүл мэндийн байгууллагын даатгалын гэрээг жил бүр дүгнээгүй байна	10
B.1.6 Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд олгосон санхүүжилт үр нөлөөтэй байна	10

БҮЛЭГ 3. Цахим мэдээллийн нэгдсэн нэг систем ашиглан тусламж, үйлчилгээг үзүүлэх шаардлагатай байна 11-13

B.2.1 Эрүүл мэндийн даатгалын хүртээмжийг нэмэгдүүлэх ажил хүм амын төвлөрсөн газарт хийгдэхгүй байна	11
B.2.2 Цахим мэдээллийн нэгдсэн нэг систем ашиглан тусламж, үйлчилгээг үзүүлэх шаардлагатай байна	12
B.2.3 Ирүүлсэн өргөдөл, гомдлыг хууль тогтоомж, журамд заасан хугацаанд шийдвэрлэсэн байна	13

БҮЛЭГ 4. Эрүүл мэндийн даатгалын дотоод хяналт сул байна 14-15

B.3.1 Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж үр дүнг тооцсон боловч хэрэгжилт хангалтгүй байна	14
B.3.2 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар болон төлбөрийн нэхэмжлэлд тавих хяналтыг нэмэгдүүлэх шаардлагатай байна	15
B.3.3 Хууль тогтоомж, журамд заасан хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлж ажилласан байна	15
B.3.4 Шилэн дансны тухай болон Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байна	16

ДҮГНЭЛТ.....	18
ЗӨВЛӨМЖ.....	19
ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ.....	20

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АДБОУБ	Аудитын дээд байгууллагын олон улсын байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
УИХ	Улсын Их Хурал
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
АЗДТГ	Аймгийн засаг даргын тамгын газар
ЭМГ	Эрүүл мэндийн газар
БӨЭТ	Бүсийн оношилгоо эмчилгээний төв
ЭМД	Эрүүл мэндийн даатгал
ЭМТҮ	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ

ХҮСНЭГТ, ДҮРСЛЭЛ, ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

Дугаар	Тайлбар	Хуудас
Хүснэгт 1	<i>Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөө</i>	7
Хүснэгт 2	Улсын төсвөөс эрүүл мэндийн даатгалыг нь хариуцах иргэдийн шимтгэлийн төсөв	7
Хүснэгт 3	Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлагын төлөвлөгөө	7
Хүснэгт 4	Даатгалд хамруулбал зохих даатгуулагчдын төлөвлөгөө	8
Хүснэгт 5	Өрхийн эрүүл мэндийн төвийн 2021, 2022 оны хөрөнгө оруулалтын жагсаалт	11
Хүснэгт 6	Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн үнэлгээ	14
Хүснэгт 7	ЭМД-ийн яамны хяналт-шинжилгээ хийсэн үнэлгээний нэгтгэл	16
График 1	<i>Иргэдээс авсан судалгааны үр дүн</i>	6
График 2	<i>Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагын сонгон шалгаруулалтад тэнцсэн байгууллагуудын ангилал</i>	9

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ АРГАЗҮЙ**Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх:**

Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны “Аудитын сэдэв батлах тухай” 2022 оны 09 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2023 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн А/04 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2023 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-нд тусгасан дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилго, хамарсан хүрээ:

Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөөнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, иргэд олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилго чиглэсэн. Аудитын зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Эрүүл мэндийн даатгалын тогтолцоо, үйл ажиллагааны үр дүн, төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн хэрэгжилт хангагдсан эсэх,
- Эрүүл мэндийн байгууллагаас даатгуулагчийн эрэлт, хэрэгцээ, шаардлагад нийцсэн эрүүл мэндийн чанартай тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа эсэх.

Аудитад аймгийн Эрүүл мэндийн газар, Эрүүл мэндийн даатгалын хэлтэс, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгч төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд, өрх, сум, багийн эрүүл мэндийн төвүүд, эрүүл мэндийн хөгжлийн төв болон Нийгмийн даатгалын хэлтсийн 2021-2022 оны үйл ажиллагааг хамруулав.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол улсын аудитын стандарт MNS 6817-5:2020, гүйцэтгэлийн аудитын зарчим MNS 6817-6:2020, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, байгууллагын худалдан авалт хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ хийх бөгөөд аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Аудитад ашиглах хууль тогтоомж шалгуур үзүүлэлтүүд:

Аудитад асуудлын шинжилгээний дагуу нарийвчлан боловсруулсан аудитын арга зүй, гүйцэтгэлийн аудитын арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэй байх зарчим болон дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

- Төрийн хэмнэлтийн тухай хууль (2022 он)
- Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль
- Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль (1996 он)
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (2005 он)
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль (2015 он)
- Шилэн дансны тухай хууль (2014 он)
- Эрүүл мэндийн тухай хууль (2011 он)

**Аудит
хийсэн
багийн
бүрэлдэхүүн:**

**Ерөнхий
мэдээлэл:**

- Эрүүл мэндийн даатгалын тухай хууль (2015 он)
- Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль (2016 он)
- Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль (2016 он)
- “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2023” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого (УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоол)
- Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай (УИХ-ын 2020 оны 24 дүгээр тогтоол)
- “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”, “Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин” (УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоол)
- Эрүүл мэндийн салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө (2021-2030 он)
- Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2020-23 оны тушаалууд
- Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын 2020-2023 оны тушаалууд
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрх зүйн актууд

Аудитыг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Өсөхбаяр хянан удирдаж, аудитын менежер Т.Хонгорзул үе шатны хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Г.Шижирболд, аудитор Т.Хишигбат нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.

УИХ-аас Эрүүл мэндийн даатгалын тухай, Эрүүл мэндийн тухай, Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуульд 2020 оны 08 дугаар сарын 18-ны өдөр оруулсан нэмэлт өөрчлөлтөөр эрүүл мэндийн даатгалын хууль, эрх зүйн орчин шинэчлэгдэж, иргэд эрүүл мэндийн даатгалд бүрэн хамрагдах, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх тусламж, үйлчилгээний төлбөрийн тариф, шалгуурыг оновчтой болгох ажлууд хэрэгжиж эхэлсэн байна.

Төрийн болон хувийн хэвшлийн эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагууд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилтийг олон улсын эмнэл зүйн удирдамжид үндэслэн оношийг хамааралтай бүлгээр нэхэмжлэх эмчилгээ, үйлчилгээний тарифыг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн “Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” 2021 оны 03 болон 04 дүгээр тогтоол, 2022 оны 05 дугаар тогтоолоор тус тус баталсан байна.

Аймгийн хэмжээнд эрүүл мэндийн даатгалд хамрагдсан даатгуулагчийн 2021 онд 63 эрүүл мэндийн байгууллагаар тусламж үйлчилгээ авсан 258,777 иргэдийн 16,163.7 сая төгрөг, 2022 онд 65 эрүүл мэндийн байгууллагаар тусламж үйлчилгээ авсан 242,707 иргэдийн 24,020.0 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус олгосон байна.

БҮЛЭГ-1**ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ҮР ДҮНД СУУРИЛСАН ТОГТОЛЦОО ЖИГДРЭЭГҮЙ БАЙНА.****Аймгийн хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд тусгасан зорилт, арга хэмжээний хэрэгжилт хангагдсан байна**

Монгол улсын 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд эрүүл мэндийн салбарыг хөгжүүлэх 8 зорилт, Өмнөговь аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд эрүүл мэндийн салбарыг хөгжүүлэх 9 зорилт, аймгийг хөгжүүлэх жилийн төлөвлөгөөнд 2021 онд 16 зорилт, арга хэмжээ, 2022 онд 18 зорилт арга хэмжээг тусгасан байна.

Аймгийн Хяналт-шинжилгээ үнэлгээний хэлтсээс эрүүл мэндийн салбарт хэрэгжүүлж байгаа хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтийг жил бүр тооцож 2021 онд 87.5%, 2022 онд 89.6% үнэлсэн байна.

Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөл хууль тогтоомж, дүрэмд заасан чиг үүргээ хэрэгжүүлсэн байна

Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд эрүүл мэндийн даатгалын удирдах дээд байгууллага нь Үндэсний зөвлөл байхаар заасан байна. Тус хуульд эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн хэрэгжүүлэх 8 үүргийг тусгасан байна.

Тухайлбал:

- 14.9.8.энэ хуулийн 9.1-д заасан Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багцад орох тусламж, үйлчилгээний жагсаалтыг эрүүл мэндийн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн батлах;
- 14.9.10.Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт олгох зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хэмжээг санхүү, төсвийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн тогтоох;
- 14.9.11.эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах журмыг санхүү, төсвийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн батлах.

Дээрх үүргийн дагуу Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн үндэсний зөвлөл нь 2022 онд “Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам”-ыг 05 дугаар тогтоолоор “Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээ”, “Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх төлбөрийн арга”, “Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх, хяналт тавих журам”-ыг баталсан байна.

Мөн журам шинэчлэн батлах тухай 02 дугаар тогтоолоор “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах журам”-ыг, “Эмийн жагсаалтыг шинэчлэн батлах тухай” 11 дүгээр тогтоолоор “Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хэмжээ”-г тус тус шинэчлэн баталж үүргээ хэрэгжүүлж ажилласан байна.

Эрүүл мэндийн даатгалын үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог сайжруулах шаардлагатай байна

Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогыг аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс бүрдүүлж, зардлыг Эрүүл мэндийн даатгалын хэлтэс хариуцаж байна.

Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогыг Эрүүл мэндийн даатгалын Ерөнхий газраас төлөвлөн Эрүүл мэндийн Яаманд хүргүүлж, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолоор аймгуудын төсвийн хуваарийг баталж байна.

Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого бүрдүүлэлтийг аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс болон сумдын нийгмийн даатгалын байцаагч нар хариуцан ажиллаж байна.

Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлагыг Эрүүл мэндийн даатгалын Ерөнхий газраас төлөвлөн Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолоор аймгуудын төсвийн хуваарийг баталж байна.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ худалдан авах гэрээний дагуу 65 байгууллага Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилт авах төлбөрийн нэхэмжлэхээ дараа сарын 5-ны өдрийн дотор илгээж, Эрүүл мэндийн даатгалын хэлтэс нэхэмжлэлийн хяналтыг сар бүр түүврийн аргаар хийдэг байна.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 05 дугаар тогтоолоор өрх, сумын эрүүл мэндийн төвөөс үзүүлэх нэг иргэнээр тооцсон тусламж, үйлчилгээг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх журам баталсан байна.

Аймгийн 15 сумын 5 сум нь 2,000 хүртэлх, 6 сум нь 2,000-3,000 хооронд, 4 сум нь 5,000 түүнээс дээш хүн амтай байна. Хүн ам цөөтэй сумын хувьд нэг иргэнээр тооцсон санхүүжилт нь иргэнд үзүүлж байгаа эмнэлгийн тусламж үйлчилгээ, оношилгооны зардлаас хэтэрдэг нь цаашид сумын эрүүл мэндийн төвөөс эрүүл мэндийн тусламж үйлчилгээг бүрэн авах боломжгүй болох эрсдэлтэй байна.

Эрүүл мэндийн даатгалын тогтолцооны шинэчлэл улсын хэмжээнд Ковид халдварт өвчний үед явагдсан учир шинэ тогтолцоог бүрэн хэрэглэж хэвшээгүй, үр дүнг тооцох хугацаа богино байна.



Аудитын талбарын үе шатанд эрүүл мэндийн даатгалын талаарх санал асуулгад эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлдөг 198 иргэний судалгаанд хамруулав. Судалгааны үр дүн дараах байдлаар гарсан байна.

График-1. **Иргэдээс авсан судалгааны үр дүн**

ЭМД-ын тогтолцоо шинэчлэгдэж гүйцэтгэлээр санхүүжилтээ авч үзүүлдэг болсон талаар мэдсэн үү?

ЭМБ-ууд үйлчилгээ

Эрүүл мэндийн даатгалаараа үйлчилгээ авахад ямар хүндрэл гардаг вэ?



БҮЛЭГ-2**ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨГ ТООЦОО СУДАЛГААНД ҮНДЭСЛЭЭГҮЙ БАЙНА****Эрүүл мэндийн даатгалын сангийн 2022 оны орлогын төлөвлөгөө 13.1%-аар тасарсан байна**

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны 01 дүгээр тогтоолоор 2021 он, Эрүүл мэндийн даатгалын Ерөнхий газрын даргын 2022 оны А/14 дугаар тушаалаар 2022 оны аймгийн Эрүүл мэндийн даатгалын сангийн нийт орлого, зарлагын төлөвлөгөөг, ажил олгогч, даатгуулагчийн төлөх шимтгэлийн орлого, шимтгэлээ өөрөө хариуцан төлдөг даатгуулагчийн шимтгэлийн орлого, улсын төсвөөс эрүүл мэндийн даатгалыг нь хариуцах иргэдийн шимтгэлийн төсвийн сарын хуваарийг тус тус баталсан байна.

Хүснэгт-1. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөө

/сая төгрөг/

№	Шимтгэлийн орлогын төрөл	2021 он	2022 он
1	Ажил олгогч, даатгуулагч төлөх шимтгэлийн орлого	8,984.9	19,099.8
2	ЭМД-ын шимтгэлээ өөрөө хариуцан төлдөг даатгуулагчийн орлого	502.4	998.8
3	Бусад орлого	9.0	-
Нийт дүн		9,496.3	20,098.6

Эх сурвалж: Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын 2021, 2022 оны тушаал

Хүснэгт-2. Улсын төсвөөс эрүүл мэндийн даатгалыг нь хариуцах иргэдийн шимтгэлийн төсөв

/сая төгрөг/

№	Шимтгэлийн төрөл	2021 он	2022 он
1	Төр хариуцсан иргэдийн шимтгэлд	84,128.5	163,706.0
2	Тусламж үйлчилгээний зардалд улсын төсвөөс олгох	496,465.2	540,423.9
Нийт дүн		580,593.7	704,129.9

Эх сурвалж: Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын 2021, 2022 оны тушаал

Эрүүл мэндийн даатгалын Ерөнхий газрын даргын 2021 оны А/10 дугаар тушаалаар 2021 он, 2022 оны А/13 дугаар тушаалаар 2022 оны оюутан суралцагчид, тодорхой хөдөлмөр эрхлээгүй иргэд, гадаадын иргэн, харьяалалгүй иргэдийн эрүүл мэндийн даатгалын хамралтын төлөвлөгөөг баталсан байна.

Хүснэгт-3. Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлагын төлөвлөгөө

/сая төгрөг/

№	Зардлын нэр	2021 он	2022 он
1	Эрүүл мэндийн даатгалын тусламж үйлчилгээний зардал	7,491.1	9,502.3
Нийт дүн		7,491.1	9,502.3

Эх сурвалж: Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын 2021, 2022 оны тушаал

Мөн Эрүүл мэндийн даатгалын Ерөнхий газрын даргын 2021 оны А/10 дугаар тушаалаар 2021 он, 2022 оны А/13 дугаар тушаалаар 2022 оны оюутан суралцагчид, тодорхой хөдөлмөр эрхлээгүй иргэд, гадаадын иргэн, харьяалалгүй иргэдийн эрүүл мэндийн даатгалын хамралтын төлөвлөгөөг баталсан байна.

Хүснэгт-4. Даатгалд хамруулбал зохих даатгуулагчдын төлөвлөгөө

/сая төгрөг/

№	Даатгуулагчдын төрөл	2021 он		2022 он	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Малчид	6,500	2,180	5,200	2,936
2	Оюутан, суралцагчид	950	182	1,200	211
3	Тодорхой хөдөлмөр эрхлээгүй иргэд	6,900	4,217	6,210	5,561
Нийт дүн		14,350	6,579	12,610	8,708

Эх сурвалж: Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын 2021, 2022 оны тушаал

Эрүүл мэндийн даатгалд хамруулбал зохих даатгуулагчдын төлөвлөгөө 2021 онд 45.8%, 2022 онд 69.1%-тай жил бүр дутуу хэрэгжсэн байгаа нь даатгалд хамруулах иргэдийн төлөвлөгөө тооцоо, судалгаанд үндэслээгүй болохыг харуулж байна.

Мөн аймгийн Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг 2021 онд 12,065.4 сая төгрөг буюу 127.1% давуулан биелүүлсэн бол 2022 онд 17,458.0 сая төгрөг буюу 13.1%-аар орлогын төлөвлөгөө тасалдсан байна. Энэ нь тооцоо судалгаагүй, өмнөх оноос хэт их өсгөж орлогын төлөвлөгөөг баталсантай холбоотой байна.

Аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс, Эрүүл мэндийн даатгалын хэлтэс эрүүл мэндийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг боловсруулдаггүй, үндэслэл, тооцоо судалгаа хийдэггүй, санал өгдөггүй шууд Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас батлагдаж ирдэг байна.

Нийгмийн даатгалын хэлтсээс эрүүл мэндийн даатгалын сангийн орлогыг бүрэн төвлөрүүлдэг гэсэн боловч эрүүл мэндийн даатгалын сангийн арилжааны банкны харилцах дансны үлдэгдэлд 2021 оны жилийн эцсээр 7.1 сая төгрөг, 2022 оны жилийн эцсээр 0.3 сая төгрөг байна.

Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтийг зохих журмын дагуу хянаж, гүйцэтгэлийг бодитой тайлагнасан байна

Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн санхүүгийн тайлангаар эрүүл мэндийн байгууллагуудад Эрүүл мэндийн даатгалын сангаас 2021 онд 12,225.1 сая төгрөг, 2022 онд 27,947.4 сая төгрөг олгосон байна.

Тодруулбал:

- БОЭТ болон хувийн хэвшлийн эмнэлгүүдэд 2021 онд 8,700.3 сая төгрөг, 2022 онд 13,439.1 сая төгрөг
- Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд 2021 онд 0.6 сая төгрөг, 2022 онд 2,586.4 сая төгрөг
- Сумын Эрүүл мэндийн төвүүдэд 2021 онд 1,853.0 сая төгрөг, 2022 онд 10,777.9 сая төгрөг
- Эмийн сангуудад 2021 онд 0.9 сая төгрөг, 2022 онд 1,144.1 сая төгрөг

Эрүүл мэндийн даатгалын сан нь Эрүүл мэндийн байгууллагуудын жилийн эцсийн тооцоо нийлсэн актын нэгтгэлээр 2021 онд 3,938.6 сая төгрөгийн авлагатай байсан бол 2022 оны жилийн эцсийн байдлаар авлагыг бүрэн барагдуулж, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас БОЭТ-ийн зөрчилд тогтоосон 11.2 сая төгрөгийн акт, Зооноз өвчин судлалын төвд 236.3 сая төгрөгийн өглөгтэй байна.

Хүний нөөцөө оновчтой удирдах шаардлагатай байна

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны А/10 дугаар тушаалаар аймгийн эрүүл мэндийн даатгалын хэлтсийн дарга 1, чанар, төлбөрийн хяналтын мэргэжилтэн 3 байхаар баталсан байна.

Гүйцэтгэлээр эрүүл мэндийн даатгалын хэлтсийн дарга, чанар, төлбөрийн хяналтын мэргэжилтэн 2 орон тоо дутуу үйл ажиллагаа явуулж байна.

Аймгийн хэмжээнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг иргэдэд 2021 онд 177 эмч, 180 сувилагч байсан бол 2022 онд 179 эмч, 171 сувилагч үзүүлж байна.

Мөн аймгийн хэмжээнд 48 эмийн сан үйл ажиллагаа явуулж байгаагаас эрүүл мэндийн даатгалаар хөнгөлөлттэй эмээр үйлчлэх 42 эмийн сан буюу 87.5% нь хамрагдсан байна.

Төрийн болон хувийн хэвшлийн 45 эрүүл мэнд байгууллага үйл ажиллагаа явуулж байгаагаас 23 анхан болон лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагууд эрүүл мэндийн даатгалаар хөнгөлөлттэй үнээр эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлж байна.


Үүнээс харахад эрүүл мэндийн даатгалын хүний нөөцийн бодлогыг сайжруулан дутагдалтай боловсон хүчнээр хангах шаардлагатай байна.

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагын сонгон шалгаруулалт ил тод байдлыг хангасан байна

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2018 оны 09 дүгээр тогтоолоор “Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах журам”-ыг баталсан бол 2022 оны 02 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан байна.

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагын сонгон шалгаруулалтад аймгийн хэмжээнд 2021 онд 63 байгууллага, 2022 онд 65 байгууллага тэнцсэн байна.

График-2. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагын сонгон шалгаруулалтад тэнцсэн байгууллагуудын ангилал



Дээрх байгууллагууд 1818.mn цахим мэдээллийн системээр дамжуулан Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулалтад ордог бөгөөд тус цахим системд сонгогдсон болон сонгогдоогүй байгууллага, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний төрөл тус бүрээр тэнцсэн, тэнцээгүй шалтгаан нөхцөл нийтэд нээлттэй харагдаж байгаа нь ил тод байдлыг хангасан байна.

Мөн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагын сонгон шалгаруулалтад тэнцсэн байгууллагын гэрээг 3 жилийн хугацаатай байгуулан тусламж үйлчилгээний нэр төрлийг хавсралтаар жил бүр өөрчлөлт хийдэг байна.

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагын сонгон шалгаруулалтад тэнцээгүй түгээмэл шалтгаан нь нарийн мэргэшлийн эмч, хүний нөөцийн дутагдалтай холбоотой байна.

Эрүүл мэндийн байгууллагуудын даатгалын гэрээг жил бүр дүгнээгүй байна

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2018 оны 12 дугаар тогтоолоор Эрүүл мэндийн даатгалын гэрээний үлгэрчилсэн загварыг баталсан байна.

Уг загварын дагуу Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас 2021 онд 63 даатгалын гэрээ, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны А/118 дугаар тушаалаар эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагын сонгон шалгаруулалтад тэнцсэн байгууллагуудтай 65 даатгалын гэрээ байгуулсан байна. **Үүнд:**

2021 он

1. Улсын эмнэлэг – 1,
2. Хувийн эмнэлэг – 4,
3. Сувилал – 1,
4. Эмийн сан – 40,
5. Өрхийн ЭМТ – 3,
6. Сумын ЭМТ – 14,
7. Сувилал – 1,

2022 он

1. Улсын эмнэлэг – 1,
2. Хувийн эмнэлэг – 4,
3. Сувилал – 1,
4. Эмийн сан – 42,
5. Өрхийн ЭМТ – 3,
6. Сумын ЭМТ – 14,
7. Сувилал – 1,

Дээрх гэрээнүүдийг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны А/03 дугаар тушаалаар батлагдсан удирдамжийн дагуу 2021 онд эмийн сангуудын гэрээ дүгнэхэд 2 эмийн сан 90-оос доош, 38 эмийн сан 90-ээс дээш оноо авсан байна. Өрх, сумын ЭМТ-ын гэрээг 14 заалтын /95 оноогоор/ дүгнэхэд үнэлгээний дундаж 78%-тай байна.

Мөн 2022 оны эмийн сангуудын гэрээг дүгнэхэд 90-с дээш оноо авсан 15, 80-89 оноо авсан 23, 70-79 оноо авсан 4 эмийн сан байна. Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн 2022 оны 01 сарын 11-ны өдрийн 01 тоот албан бичгээр 23 эмийн санд зөвлөмж, 2023 оны 01 сарын 27-ны өдрийн 25/26, 25/27, 25/28, 25/29 тоот албан бичгээр нийгмийн даатгалын шимтгэл, татварын өргүй байх, MNS 5260:2015 стандартыг мөрдөж ажиллах 4 эмийн санд шаардлага хүргүүлж хэрэгжилтийг хангуулан ажилласан байна.

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын Худалдан авалт, гэрээлэлтийн газраас өрх, сумын эрүүл мэндийн төвүүд 1 иргэний шалгуур үзүүлэлтээ буруу өгөөд байгаа тул аргазүйн зөвлөгөө өгч байж 2022 оны даатгалын гэрээг дүгнэнэ гэсэн чиглэлийн дагуу Эрүүл мэндийн даатгалын хэлтэс нь 2022 оны даатгалын гэрээг дүгнээгүй байна.

Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд олгосон санхүүжилт үр нөлөөтэй байна

Аймгийн хэмжээнд 2021 онд 63 байгууллагад 12,225.1 сая төгрөг, 2022 онд 65 эрүүл мэндийн байгууллагад 27,947.4 сая төгрөгийн санхүүжилт олгож, 15,722.3 сая төгрөгөөр өссөн байна.

БОЭТ болон сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн жилийн эцсийн санхүүгийн тайлангаар мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн үлдэгдэл 2020 онд 44.1 сая төгрөг, 2021 онд 93.3 сая төгрөг, 2022 онд 2,174.9 сая төгрөгөөр тайлагнасан байна.

Энэ нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.11.4-д “Эрүүл мэндийн даатгалын сангаас эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд зарцуулах зардлын төлбөр нэмэгдсэн нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд улсын төсвөөс олгох санхүүжилтийг бууруулах үндэслэл болохгүй” гэсэн заалтын дагуу сум, өрхийн улсын төсвөөс санхүүжилт буураагүй, эрүүл мэндийн даатгалын сангаас олгосон санхүүжилт өндөр авдаг болохыг харуулж байна.

Бүсийн оношилгоо төвийн жилийн эцсийн санхүүгийн тайланд 2020 онд 8.9 сая төгрөгийн авлага, 2021 онд 1,953.8 сая төгрөгийн авлага, 1,437.0 сая төгрөгийн өглөг, 2022 онд 20.6 сая төгрөгийн авлага, 1,059.2 сая төгрөгийн өглөгтэй тайлагнасан байна.

Тус байгууллага нь эрүүл мэндийн даатгалын сангаас 100% гүйцэтгэлээр санхүүждэг учир шинэ тогтолцоонд шилжсэнээр санхүүжилт үр ашиггүй гэж харагдах боловч сүүлийн 2 жилийн хугацаанд 2,496.2 сая төгрөгийн өртэй болсон хэдий ч эрүүл мэндийн даатгалын сангаас нэхэмжилсэн дүнгээс 2021 он 804.2 сая төгрөг, 2022 онд 987.6 сая төгрөгийн санхүүжилт хасагдсан нь нөлөөлсөн байна.

Өрхийн эрүүл мэндийн төвүүд эрүүл мэндийн даатгалын сангаас авсан санхүүжилтийг шаардлагатай хөрөнгө оруулалтад зарцуулсан байна.

Хүснэгт-5. Өрхийн эрүүл мэндийн төвийн 2021, 2022 оны хөрөнгө оруулалтын жагсаалт
/сая төгрөг/

№	Өрхийн эрүүл мэндийн төвийн нэрс	2021 он	2022 он
1	Өнө орших өрхийн эрүүл мэндийн төв	3.5	100.6
2	Энхийн хүслэн өрхийн эрүүл мэндийн төв	4.8	141.3
3	Шим билэг өрхийн эрүүл мэндийн төв	3.2	160.0

Эх сурвалж: Өрхийн эрүүл мэндийн төвүүдээс авсан судалгаа

Өрхийн эрүүл мэндийн төвүүд Эрүүл мэндийн даатгалын тогтолцоонд шилжсэнээр дараах давуу талтай байна. Үүнд:

- Эмч, ажилчдын цалин хөлс нэмэгдсэнээр тогтвор суурьшилтай ажиллах боломжтой бүрдсэн,
- Өрхийн эрүүл мэндийн төвдөө шаардлагатай тоног төхөөрөмжийг худалдан авах боломж нэмэгдсэн,
- Иргэдэд анхан шатны эрүүл мэндийн тусламж үйлчилгээг илүү хүртээмжтэй байдлаар хүргэдэг болсон.

БҮЛЭГ-3**ЦАХИМ МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН НЭГ СИСТЕМ АШИГЛАН
ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭГ ҮЗҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.****Эрүүл мэндийн даатгалын хүртээмжийг нэмэгдүүлэх ажил хүн амын төвлөрсөн газарт хийгдэхгүй байна**

Аймгийн Засаг даргатай байгуулсан сумдын Засаг дарга нарын 2022 оны гэрээнд Эрүүл мэндийн даатгал, шимтгэл төлөлтийг нэмэгдүүлэх талаарх заалтыг оруулсан байна.

Аймгийн ЗДТГ, ЭМГ, БОЭТ, Эрүүл мэндийн даатгалын хэлтэс хамтран 2022 онд 8 суманд явуулын оффисын үйлчилгээг хүргэн, Эрүүл мэндийн даатгалын талаар сумдын эрүүл мэндийн төвийн эмч, ажилчид, иргэдэд мэдээлэл, сурталчилгаа хийж, 100 гаруй иргэдийг шинээр эрүүл мэндийн даатгалд хамруулсан байна.

Мөн 2022 онд халамж үйлчилгээний бүртгэлд байдаг эмзэг бүлгийн 1440 иргэний эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг төрөөс төлж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлж ажилласан байна.

Анхан шатны болон лавлагаа шатлалын эмнэлэг, эмийн сангаар эрүүл мэндийн тусламж үйлчилгээ хүлээн авах иргэдэд эрүүл мэндийн даатгалын талаарх мэдээллийг мэдээллийг самбарт байршуулан, эмч ажилтнууд амаар хэлдэг байна.

Эрүүл мэндийн даатгалын хэлтэс нь төлбөрийн нэхэмжлэлийн ачаалалтай байдаг тул БОЭТ, өрхийн эрүүл мэндийн төв, аймгийн төвийн иргэдэд эрүүл мэндийн даатгал болон эрүүл мэндийн туламж үйлчилгээний талаарх мэдээллийг иргэдэд сурталчлан таниулах, мэдээлэх ажил зохион байгуулдаггүй байна.

Цахим мэдээллийн нэгдсэн нэг систем ашиглан тусламж, үйлчилгээг үзүүлэх шаардлагатай байна

Төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага, Эрүүл мэндийн даатгалын байгууллагууд тус тусдаа өөр өөрсдийн программыг хэрэглэж байна.

Тухайлбал:

- Эрүүл мэндийн даатгалын байгууллага HEALTH.GOV.MN цахим программ
- Өрх, сумын эрүүл мэндийн төвүүд E-HOSPITAL программ
- Хувийн хэвшлийн эмнэлгүүд WINGS SYTEM, E-CLINIC программ
- Эмийн сангууд МАРГАД, МАКС, БУМАН IT, ОДОО, ОРИОН гэх мэт программ

Эдгээр программууд нь хооронд шууд мэдээлэл дамжуулдаггүй, эрүүл мэндийн даатгалын систем рүү хөрвүүлж холбогддог бөгөөд гацах, системд давхардал үүсэх, оруулсан мэдээллүүд устгагдах зэрэг алдаа түгээмэл байдаг байна.

Эрүүл мэндийн байгууллагуудын ашиглаж байгаа E-hospital.mn цахим системийг өөрчлөн өмнө нь ашиглаж байсан health.gov.mn цахим системд хөгжүүлэлт хийж 2023 оны 05 сарын 15-ны өдрөөс ашиглаж эхэлсэн байна.

Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/813 дугаар тушаалаар баталсан “Эрүүл мэндийн байгууллага болон шатлал хооронд үйлчлүүлэгчийг шилжүүлэх” журмын 2.1.3 “Анхан шатны эрүүл мэндийн байгууллагаас лавлагаа шатлалд шилжүүлэхдээ “Эмнэлэгт өвчтөн илгээх хуудас АМ-13А маягт”-г бүрэн бөглөж илгээнэ”, 2.1.4 “Үйлчлүүлэгчид “Эмнэлэг өвчтөн илгээх хуудас АМ-13А маягт”-ыг цахимаар илгээх бөгөөд мөн хэвлэж өгч болно” гэж заасан байдаг.

Энэ заалтыг хэрэгжүүлэхэд төрийн болон хувийн эмнэлгийн байгууллагын хооронд программын хүндрэл их гардаг байна. Үүнд:

- Анхан шатны эрүүл мэндийн байгууллагаас хувийн лавлагаа шатлалын байгууллагад цахимаар АМ-13А маягтыг шууд илгээх боломж байдаггүй,
- Анхан шатны эрүүл мэндийн байгууллагаас төрийн лавлагаа шатлалын байгууллага буюу Бүсийн оношилгоо эмчилгээний төв рүү шилжүүлдэг. Тус байгууллага оочир дараалал ихтэй, ачаалалтай үед иргэд хувийн эмнэлэгт үзүүлэх гэхээр АМ-13А маягтыг тухайн хувийн эмнэлэг рүү цахимаар илгээх боломжгүй тул анхан шатны эрүүл мэндийн байгууллагад дахин очиж цаасаар авах шаардлага үүсдэг нь иргэдэд хүндрэл үүсгэдэг байна.

Дээрх шалтгааны улмаас төрийн хувийн гэж ялгаа үүсгэхгүй төрийн эрүүл мэндийн байгууллагын ашиглаж байгаа программыг хувийн хэвшлийн байгууллагууд хэрэглэдэг байхаар өөрчлөх шаардлагатай байна.

Ирүүлсэн өргөдөл, гомдлыг хууль тогтоомж, журамд заасан хугацаанд шийдвэрлэсэн байна

Аудитын явцад эрүүл мэндийн даатгалд хамрагддаг 198 иргэдээс цахимаар болон цаасаар судалгаа авч Эрүүл мэндийн даатгал, эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбоотой мэдээллийг та хаанаас авдаг вэ? гэсэн асуултад давхардсан тоогоор дараах байдлаар хариулсан байна.

Үүнд:

- | | |
|-----------------------------------|---------|
| 1. ЭМДЕГ-ын албан ёсны сайт, пэйж | - 6.6% |
| 2. Олон нийтийн сүлжээ | - 36.7% |
| 3. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл | - 16.8% |
| 4. Өрхийн эмнэлэг, хороо | - 18.6% |
| 5. Мэдээлэл авдаггүй | - 7.5% |
| 6. Ам дамжсан яриа | - 12.8% |
| 7. Бусад | - 1.0% |

Энэ нь найдвартай эх сурвалжаас мэдээлэл авдаггүй, мэдээллийг иргэдэд хүргэх мэдлэг муу байгааг харуулж байгаа бөгөөд нэгдсэн нэг мэдээллээр хангах үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай байна.

Аймгийн эрүүл мэндийн даатгалын хэлтэст 2021 онд 2 өргөдөл, 2022 онд 1 өргөдөл ирж цаг хугацаанд бүрэн шийдвэрлэсэн байна. Тухайлбал:

2021 он : Иргэн А.Д, Д.Б нарын Хөнгөлөлттэй эм бичүүлэх үед хурууны хээ уншихгүй байна, Регистрийн дугаараар эм бичдэг болгож өгнө үү гэсэн өргөдлийн дагуу холбогдох баримт бичгүүдийг нэхэмжлэлийн хяналтын хэлтсийн мэргэжилтэнд хүргүүлж, регистрийн дугаараар эм бичүүлдэг болсон,

2022 он: Иргэн Г.Н, Өмнөговь аймгийн БОЭТ нь хамтын төлбөрөөс гадна эмнэлгийн хэрэгсэл авхуулсан тухай өргөдлийн дагуу БОЭТ-д тухайн иргэний хохирлыг барагдуулах болон гэрээний үүргээ биелүүлж ажиллах талаар албан бичиг хүргүүлж БОЭТ тухайн иргэний эм, эмнэлгийн хэрэгсэл авхуулсан дүнг тухай иргэний дансанд шилжүүлсэн байна.

Мөн Монгол Улсын Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах 11-11 төвд эрүүл мэндийн байгууллагуудын иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаатай холбоотой 2021 онд 1, 2022 онд 6 иргэдийн гомдол ирснийг цаг хугацаанд нь шийдвэрлэж тухайн иргэдэд хариу мэдэгдсэн байна.

БҮЛЭГ-4**ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ДОТООД ХЯНАЛТ СУЛ БАЙНА****Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж үр дүнг тооцсон боловч хэрэгжилт хангалтгүй байна**

Аймгийн Хяналт-шинжилгээ үнэлгээний хэлтсээс Эрүүл мэндийн газрын үйл ажиллагааны гүйцэтгэлд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж 2021 онд 70.8%, 2022 онд 3.2 оноогоор буюу 64%-аар үнэлсэн байна.

Мөн Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн үйл ажиллагаа, бодлогын баримт бичиг, тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, үр дүнд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээгээр 2022 онд 30%-тай “Хангалтгүй” гэж үнэлэгдсэн байна.

Хүснэгт-6. Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн үнэлгээ

№	Шалгуур үзүүлэлт	Оноо
1	Хууль, тогтоомж, тогтоо, шийдвэр	0
2	Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоол, шийдвэр	0
3	Аймгийн Засаг даргын захирамж, албан даалгавар	0
4	Байгууллага, ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг стандарт шаардлага, журмын дагуу боловсруулж, баталгаажуулсан байдал, хэрэгжилт	3.5
5	Төрийн албаны стандарт хангалт, ТАХ-ийн хувийн хэргийн бүрдэл	2.0
6	Төрийн үйлчилгээний болон албан хаагчдын хөдөлмөрийн гэрээ	-
7	Байгууллагын ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт	3.0
Дундаж оноо		1.5

Эх сурвалж: Аймгийн Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн ЭМДХ-т хийсэн 2022 оны үйл ажиллагааны гүйцэтгэлд хийсэн хяналт-шинжилгээ үнэлгээний тайлан

Дээрх Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангаар Эрүүл мэндийн даатгалын хэлтэст 7 чиглэлээр 10 зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Тодруулбал:

- Бодлогын баримт бичиг тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулж байгаа байдлын талаар 5 зөвлөмж,
- Байгууллага, Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг стандарт шаардлага журмын дагуу боловсруулж, баталгаажуулсан байдал, хэрэгжилтийн талаар 2 зөвлөмж,
- Төрийн албаны стандарт хангалт, Төрийн албан хаагчийн хувийн хэргийн бүрдлийн талаар 2 зөвлөмж,
- Төрийн үйлчилгээний болон албан хаагчдын хөдөлмөрийн гэрээний талаар 1 зөвлөмж
- Байгууллагын ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийн талаар 1 зөвлөмж

Дээрх үнэлгээний үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын хэсгээс өгсөн зөвлөмжийг хүргүүлсэн боловч хэрэгжүүлсэн мэдээ, тайланг тус хэлтэст ирүүлээгүй байна.

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар болон төлбөрийн нэхэмжлэлд тавих хяналтыг нэмэгдүүлэх шаардлагатай байна

Эрүүл мэндийн даатгалын хэлтэс нь Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 12 дугаар тогтоолоор баталсан "Чанар, төлбөрийн хяналтын журам"-ын дагуу

төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд, эмийн сангуудын Эрүүл мэндийн даатгалын сангаас нэхэмжилсэн төлбөрийн нэхэмжлэлд чанарын хяналтыг сар болгон түүврийн аргаар хийж гүйцэтгэсэн байна.

Нэхэмжлэлийн хяналтаар дараах байдлаар хасагдсан байна. Үүнд:

- Бүсийн оношилгоо эмчилгээний төв 2021 онд 987.6 сая төгрөг, 2022 онд 804.2 сая төгрөг
- Өрхийн эрүүл мэндийн төвүүд 2021 онд 211.2 сая төгрөг, 2022 онд 40.6 сая төгрөг
- Сумын эрүүл мэндийн төвүүд 2021 онд 406.4 сая төгрөг, 2022 онд 349.7 сая төгрөг
- Хувийн хэвшлийн эмнэлгүүд 2021 онд 16.2 сая төгрөг, 2022 онд 62.8 сая төгрөг
- Эмийн сангууд 2021 онд 5.6 сая төгрөг, 2022 онд 11.1 сая төгрөг

Нэхэмжилсэн дүн хасагдсан шалтгаан нь Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/611 дүгээр тушаалаар баталсан "Эрүүл мэндийн салбарын статистик мэдээ, мэдээллийн журам, бүртгэлийн маягтыг шинэчлэн батлах тухай" журмыг бүрэн хэрэгжүүлж ажиллахгүй байгаатай холбоотой байна.

Эрүүл мэндийн даатгалын хэлтэс нь хүний нөөцийн дутагдалтай байгаа тул ажлын ачааллаас шалтгаалан 2021, 2022 онд нэхэмжлэлийн хяналтын хасагдлын талаарх мэдээллийг тухайн эрүүл мэндийн байгууллагад мэдэгддэггүй, сумын эрүүл мэндийн төвүүдийн шалгуур хангаагүй хасагдлын хувийг тухайн нэхэмжлэлийн хугацаанд хамаарах нийт нэхэмжлэлийн эх олонлогт нь ногдуулах буюу нийт мөнгөн дүнгээс хасаж тооцоогүй байна.

Уг зөрчлүүдэд Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 12 дугаар тогтоолоор баталсан "Чанар, төлбөрийн хяналтын журам"-ын 4.1.1.5, 4.1.2.3-д заасныг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

Эрүүл мэндийн даатгалын дотоод хяналт сул байна

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан 2022 оны 32 дугаар тушаалаар баталсан "Хяналт шалгалтын удирдамж"-ийн дагуу аймгийн БОЭТ-н Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай байгуулсан "Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авах гэрээ"-ний үүргийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийсэн байна.

Тус шалгалтаар төлбөрийн хэмжээг илүү нэхэмжилсэн 7 даатгуулагчийн 11.2 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосон байна.

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас даатгалын гэрээ байгуулсан эрүүл мэндийн байгууллагуудад жилд 1 удаа хяналт шалгалт хийдэг боловч эрүүл мэндийн даатгалын хэлтэст чанар, төлбөрийн хяналтыг үнэн зөв шалгасан эсэхэд хяналт тавихгүй байна.

Эрүүл мэндийн яамнаас аймгийн Эрүүл мэндийн газрын 2022 оны гүйцэтгэлд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол, 2021 оны 374 дүгээр тогтоол болон Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/346 дугаар тушаалаар баталсан "Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж 64.4%-тай үнэлсэн байна.

Хүснэгт-7. ЭМД-ийн яамны хяналт-шинжилгээ хийсэн үнэлгээний нэгтгэл

№	Үзүүлэлт	Жин	Гүйцэтгэлийн хувь	Үнэлгээний жин
1	Байгууллагын тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	0.20	80.4%	16.1
2	Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт	0.15	73.2%	11.0

3	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлтийн биелэлт	0.30	72.9%	21.9
4	Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын хэрэгжилт	0.15	63.3%	9.5
5	Хэрэглэгчийн үнэлгээ	0.20	30.0%	6.0
ҮНЭЛГЭЭ			64.4%	

Эх сурвалж: Эрүүл мэндийн яамны аймгийн ЭМГ-ийн 2022 оны үйл ажиллагааны гүйцэтгэлд хийсэн хяналт-шинжилгээ үнэлгээний тайлан

Тус үнэлгээнд үндэслэн 5 чиглэлээр 28 зөвлөмжийг хүргүүлсэн байна. Тухайлбал:

1. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, түүний хэрэгжилтийн талаар 7 зөвлөмж,
2. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах чиглэлээр 7 зөвлөмж
3. Мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангах чиглэлээр 6 зөвлөмж
4. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын талаар 5 зөвлөмж
5. Хэрэглэгчийн үнэлгээний талаар 3 зөвлөмж

Шилэн дансны тухай болон Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байна.

Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний 17 байгууллагаас Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газраас 6, хувийн аудитын компани 11 байгууллагын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийсэн байна. Тус аудитаар 8 өөрчлөлтгүй, 4 хязгаарлалттай дүгнэлт өгч, 5 байгууллагыг түүвэрт хамруулсан байна.

Аудитаар Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой 12 байгууллагаас 16 төрлийн 1,787.4 сая төгрөгийг зөрчлийг илрүүлж 1,760.9 сая төгрөгийн зөрчилд 12 албан шаардлага, 26.5 сая төгрөгийн зөрчилд 4 зөвлөмжийг тус тус хүргүүлсэн байна. Тодруулбал:

Албан шаардлага:

1. *Сээрэй сумын ЭМТ:*
 - Шилэн дансны мэдээллийг тулган баталгаажуулахад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 6 гүйлгээ буюу 86,655,928.91 төгрөгийн, зарлагын 1 гүйлгээ буюу 2,514,100 төгрөгийн мэдээлэл байршуулаагүй,
 - Тайлант онд иргэдээс өгсөн ковидын хандив 352,456 төгрөгийн зарцуулалтыг шилэн дансны системд мэдээлээгүй,
 - Байгууллагын даргын 2,514,100 төгрөгийн 6 шийдвэрийн мэдээллийг байршуулаагүй,
 - Аудитын зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг байршуулаагүй,
2. *Ханхонгор сумын ЭМТ*
 - Шилэн дансны мэдээлэлд 16 буюу 276,613,294 төгрөгийн мэдээллийг мэдээлээгүй,
3. *Өмнөговь аймгийн Зоонозын өвчин судлалын төв*
 - Тухайн жилийн баталсан төсөв, төсвийн гүйцэтгэлийн хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан тайлбарыг оруулаагүй, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын 276,438,540 төгрөгийн 17 ажил гүйлгээг мэдээлээгүй,
 - Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг хавсаргаагүй,

4. *Баяндалай, Булган, Гурвантэс, Мандал-Овоо, Цогт-овоо сумын эрүүл мэндийн төвүүд*
- Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаа хоцроосон, дутуу байршуулсан,

Зөвлөмж:

1. *Эрүүл мэндийн газар, Баян-Овоо, Хүрмэн, Номгон сумдын эрүүл мэндийн төвүүд*
- Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаа хоцроосон, дутуу байршуулсан,

Мөн Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 5 байгууллагаас 8 төрлийн 155.8 сая төгрөгийн зөрчил ирүүлж 18.9 сая төгрөгийг зөрчилд 5 төлбөрийн акт, 122.8 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 14.2 сая төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгсөн байна. Тодруулбал:

Төлбөрийн акт:

1. *Аймгийн Эрүүл мэндийн газар*
 - Байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авсан,
 - Төсвийн хөрөнгөөр согтууруулах ундаа худалдан авсан,
2. *Номгон сумын ЭМТ*
 - Хууль журамд заагаагүй тэтгэмж илүү тооцож олгосон
3. *Ханбогд, Мандал-Овоо сумын ЭМТ*
 - Төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авсан

Албан шаардлага

1. *Аймгийн Зооноз өвчин судлалын төв*
 - Бараа материалын үлдэгдэлд нөөц байхад 2022 оны 11, 12 дугаар сард 121,366,000 төгрөгийн өртөг бүхий нүүрний хаалт, хошуувч, комбинезон, сарс оношлуур, кит, бусад хэрэгсэл бэлтгэсэн,
2. *Аймгийн Эрүүл мэндийн газар*
 - Байгууллагын шилдэг ажилтныг шалгаруулж, 2 ажилтанд нэг сарын үндсэн цалингаар урамшуулал олгосон,

Зөвлөмж

1. *Аймгийн Зооноз өвчин судлалын төв*
 - БСБ КОММЕРС" ХХК-аас 14,214,400 төгрөгөөр принтер, компьютер, тоног төхөөрөмж зэргийг шууд худалдан авсан байна.

Дээрх Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчлүүд жил бүр давтан гарч байгаа нь хуулийн хэрэгжилт хангалтгүй байгааг харуулж байна

Харин аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн төсвийн санхүүгийн зарцуулалтыг ЭМДЕГ-аас хийдэг тул Шилэн дансны тухай болон Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг орон нутагт шалгах боломжгүй байна.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

- ✓ Эрүүл мэндийн даатгалын тогтолцоо, үйл ажиллагаа бүрэн хэвшээгүй, тогтолцооны үр дүнг тооцох хугацаа богино байна.
- ✓ Аймгийн хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд тусгасан зорилт, арга хэмжээний хэрэгжилт хангагдсан байна.
- ✓ Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөл хууль тогтоомж, дүрэмд заасан чиг үүргээ хэрэгжүүлсэн байна.
- ✓ Эрүүл мэндийн даатгалын үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог сайжруулах шаардлагатай байна.
- ✓ Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг тооцоо судалгаанд үндэслээгүй байна.
- ✓ Эрүүл мэндийн даатгалын сангийн 2022 оны орлогын төлөвлөгөө 13.1%-аар тасарсан байна.
- ✓ Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтийг зохих журмын дагуу хянаж, гүйцэтгэлийг бодитой тайлагнасан байна.
- ✓ Хүний нөөцөө оновчтой удирдах шаардлагатай байна.
- ✓ Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагын сонгон шалгаруулалт ил тод байдлыг хангасан байна.
- ✓ Эрүүл мэндийн байгууллагын даатгалын гэрээг жил бүр дүгнээгүй байна.
- ✓ Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд олгосон санхүүжилт үр нөлөөтэй байна.
- ✓ Эрүүл мэндийн даатгалын хүртээмжийг нэмэгдүүлэх ажил хүм амын төвлөрсөн газарт хийгдэхгүй байна.
- ✓ Цахим мэдээллийн нэгдсэн нэг систем ашиглан тусламж, үйлчилгээг үзүүлэх шаардлагатай байна.
- ✓ Ирүүлсэн өргөдөл, гомдлыг хууль тогтоомж, журамд заасан хугацаанд шийдвэрлэсэн байна.

ЗӨВЛӨМЖ**❖ Бүсийн оношилгоо эмчилгээний төвд**

1. Тус байгууллагад дутагдалтай байгаа хүний нөөцийг бүрдүүлэх талаар байгууллагын удирдлага болон холбогдох бусад байгууллагуудтай хамтарч ажиллах, иргэдийг эрүүл мэндийн даатгалаар эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах боломжийг бүрдүүлж ажиллах,
2. Эвдэрч гэмтсэн тоног төхөөрөмжийг хэвийн ажиллагаанд оруулан Эрүүл мэндийн ерөнхий газартай 2022 оны 09 сарын 05-ны өдөр байгуулсан "Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авах гэрээ"-г хэрэгжүүлж ажиллах зөвлөмж хүргүүлэх,

❖ Үндэсний аудитын газарт уламжлах нь

1. Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар нь эрүүл мэндийн даатгалаар хөнгөлөлттэй эмийн жагсаалтыг нэмэгдүүлэх, үнэ тарифыг өсгөх талаар бодитой тооцоо, судалгаа хийх
2. Мөн хяналт шалгалт, дотоод аудит нь эрүүл мэндийн даатгалын хэлтэст чанар, төлбөрийн хяналтыг үнэн зөв хийж эсэхэд хяналтыг сайжруулах.

ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН
ХЭЛТЭС**

Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46080

Утас/Факс: (976) 7053 3020,

Цахим шуудан: um.emdheltes@emd.gov.mn,

Цахим хуудас: www.emd.gov.mn

2023.08.12 № 25/131

танай _____-ны № _____-т

Санал хүргүүлэх тухай

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Ц.ӨСӨХБАЯР ТАНАА

Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо үр нөлөө сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлан, асуудлын бүртгэлд санал тайлан байхгүй болно.

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
ЧАНАР ТӨЛБӨРИЙН ХЯНАЛТЫН МЭРГЭЖИЛТЭН



А.ЭНХЧИМЭГ

ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОРЫН ТУШААЛ

2023 оны 05 сарын 19 өдөр

Дугаар А/15

Даланзадгад сум

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, 9 дүгээр зүйлийн 9.1, 29 дүгээр зүйлийн 29.4 дэхь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ийн 18.9-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг нэгдүгээр хавсралтаар, албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталгаажуулсугай.
2. Аудитын тайланг Үндэсний аудитын газар, аймгийн Засаг дарга, Эрүүл мэндийн даатгалын хэлтэст тус тус хүргүүлсүгэй.
3. Аудиттай холбоотой ажлын нотлох баримтыг тайлан баталгаажуулснаас хойш 14 хоногийн дотор архивын нэгж болгон хүлээлгэн өгөх, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор (Г.Шижирболд)-д даалгасугай.



Ц.ӨСӨХБАЯР

D:\2023 Он\Бичиг Хэрэг\А Тушаал\А-15.Doc

016010026